

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 07-р сарын 09-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Гашууны голын төмөр бетон гүүрийн их засвар, 72 у/м /Увс, Улаангом сум/**

Тендер шалгаруулалтын дугаар: **ЗТХЯ/201801004**

Зам, тээврийн хөгжлийн яам нь МУ-ын 2018 оны Төсвийн тухай хуулийн 2-р хавсралтаар баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт дахь “XIV.1.2.18 Гашууны голын төмөр бетон гүүрийн их засвар, 72 у/м /Увс, Улаангом сум/”-ын ажил гүйцэтгэх тухай **цахим** тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулагдана.

Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50.000 /тавин мянга/ төгрөгөөр цахимаар худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендер оролцогч этгээд нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буйг нотлох ба дараах туршлагын болон санхүүгийн ерөнхий шаардлагыг хангасан байвал зохино. **Үүнд:**

- Төмөр бетон гүүр барих эсвэл засварлах ажлын тусгай зөвшөөрөлтэй байх
- Сүүлийн 5 жил буюу 2013, 2014, 2015, 2016, 2017 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь 1 000 000 000.0 /нэг тэрбум/ төгрөгөөс багагүй байх,
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: 300 сая төгрөгнөөс багагүй байх,
- Сүүлийн 5 жил буюу 2013, 2014, 2015, 2016, 2017 онуудын аль нэг жилд тендер санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас доошгүй хэмжээний ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж гүйцэтгэсэн байх. /Гэрээ болон ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын актыг хавсаргана/
- Тендерийн хамт 21 000 000.0 /хорин нэг сая/ төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг **2018 оны 08 дугаар сарын 10-ны 11.00 цагаас** өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 11.30 цагт** нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.
Дотоодын давуу эрх тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн талаарх нэмэлт мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11, Засгийн газрын байр 13,
Зам, тээврийн хөгжлийн яам 411 тоот, Авто замын бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын мэргэжилтэн Б.Дархандарьяа**

Утас-62263185, факс- 11312315